



ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ТАЙЛАН
2024

3 - 6

Бидний тухай

Өмнөх үг	3
Бидний тухай	4
Тайлангийн цар хүрээ	5
2024 оны онцлох үзүүлэлтүүд	6

21 - 36

Нийгэм

Олон янз байдал ба хүртээмжтэй ажлын байр	22
Сайн дурын үйл ажиллагааг дэмжих	26
Сургалт хөгжил ба чадавх бэхжүүлэх	27
Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй	30
Олон нийт, нийгэмд чиглэсэн арга хэмжээ	31

7 - 9

Тогтвортой хөгжлийн стратеги

Байгаль орчин, нийгэм, засаглалын стратеги	8
Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга зам	9

37 - 47

Засаглал

Засаглалын бүтэц	38
Эрсдэлийн менежмент	40
Нийцлийн удирдлагын тогтолцоо	42
Спийк-аут	44
Тогтвортой нийлүүлэлтийн гинжин хэлхээ ба худалдан авалт	45
Эдийн засагт оруулж буй хувь нэмэр	47

10 - 20

Байгаль орчин

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах	11
Эрчим хүчний менежмент	13
Байгалийн нөөцийн зөв зохистой хэрэглээ	16
Биологийн олон янз байдал	18
Хог хаягдлын менежмент	19



Өмнөх үг

М-Си-Эс Групп нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсээр байна. Тайлант онд бид олон улсын стандартад тулгуурлаж, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллөө тооцох, цаашлаад хүлэмжийн хийн ялгарлыг үе шаттайгаар бууруулах арга зүйг үйл ажиллагаа эрхэлж буй бизнесийн салбар бүрийнхээ онцлогт тохируулан шинэчлэн боловсрууллаа.

Улмаар хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг бизнесийн салбарууддаа цэвэр эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Монгол Улсын зорилтод хувь нэмрээ оруулсаар байгаа юм.

Түүнчлэн хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах, дахин ашиглах бодлогыг тууштай баримтлан ажиллаж байна. Тухайлбал М-Си-Эс Кока-Кола компани нийт борлуулсан PET-1 тэмдэглэгээтэй бүтээгдэхүүний хуванцар савны 56 хувийг буцаан цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгсөн нь өмнөх онтой харьцуулахад 16 хувиар өссөн бол Юнител Групп хаягдал төхөөрөмжүүдийг зохих журмын дагуу устгаж дахин боловсруулах зорилгоор 2024 онд 12 мянга орчим хуучин төхөөрөмжүүдийг хэрэглэгчдээсээ цуглуулж, дахин боловсруулалтад хүлээлгэн өгсөн юм.

М-Си-Эс Групп тайлант онд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хаваржилт хүндэрсэн аймгуудад 1.1 тэрбум гаруй төгрөгийн тусламж, дэмжлэг үзүүллээ. Мөн оюутан залуучуудын хөгжил дэвшил болон боловсролыг дэмжих зорилгоор найман их сургуулийн 78 оюутныг шалгаруулан нэг жилийн сургалтын тэтгэлэг олгож,

мэргэжлийн чиглэлээрээ гурван сарын хугацаатай цалинтай дадлага хийх боломжоор хангасан билээ.

“Дэлхийн хөгжлийг Монголдоо цогцлоох” хамтын зорилгын хүрээнд ажилтнууд маань улс эх орныхоо болон компанийнхаа хөгжилд бодитой дэмжлэг үзүүлж буйг нь үнэлж, сард 60 орчим тэрбум төгрөгийн цалин, урамшуулал олгожээ. Бид орчин үед тавигдаж байгаа ажлын байрны шаардлага болох уян хатан ажлын цаг, тав тухтай, хөдөлмөрийн аюулгүй ажиллах орчныг бүрдүүлснээр ажилтнуудын ажлын үр бүтээмж, амьдралын чанар дээшилсээр байгаа юм.

Мөн ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулж ирсэн ба өнгөрсөн жилээс хувийн эрүүл мэндийн даатгалд гэр бүлийн хамтаар хөнгөлөлттэй үнээр хамрагдах боломжийг олгож эхэллээ.

Тогтвортой ирээдүйг бий болгох урт хугацааны зорилго, зорилтдоо хүрэхээр хэрэгжүүлж буй бидний ахиц, дэвшил болон амжилтуудаа энэхүү тайлангаараа бид хүргэж байна.



Бидний тухай

Эрчим хүчний зөвлөгөө өгөх чиглэлээр 1993 онд үүсгэн байгуулагдсан М-Си-Эс Групп нь эрчим хүч, дэд бүтэц, инженеринг, мэдээлэл, харилцаа холбоо, барилга, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, хөдөө аж ахуй, банк санхүү, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, эрүүл мэнд зэрэг салбарт үйл ажиллагаа эрхэлж, татвар шимтгэл, хөрөнгө оруулалт, ажлын байр зэрэг үзүүлэлтээр улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж, тогтсон байгууллагын соёлтой, төлөвшсөн боловсон хүчинтэй, түүчээлэх чадвартай үндэсний Групп компани болон тэлжээ.

Бид нийгэм, улс орон, эх дэлхийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, дэлхийн шилдэг стандарт, дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлж, олон улсын хөрөнгө оруулагчид болон түншүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлж, байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоог нэвтрүүлэн, урт хугацаанд тогтвортой хөгжлийн зорилгуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.






Тайлангийн цар хүрээ

М-Си-Эс Групп нь бизнесийн бүхий л салбарынхаа үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийг тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд бидний үйл ажиллагаанаас үүсэж болох аливаа сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ болон, байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ёс зүйтэй бизнесийн зарчмыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж, жил бүр Тогтвортой хөгжлийн тайлангаараа дамжуулан олон нийтэд ил тод хүргэдэг билээ.

Нээлттэй, ил тод, хариуцлагатай засаглал бүхий ёс зүйтэй бизнесийн соёлыг төлөвшүүлэх нь М-Си-Эс Группийн Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын стратегийн гол цөм юм. Тийм ч учраас бид үйл ажиллагааныхаа нөлөөллийг бүх түвшинд харгалзан үзэж, оролцогч талууд болон нийгэмд бодит үнэ цэн нэмэх тогтвортой санаачилга, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг зорин ажилладаг.

Монгол Улсын нийгэм, эдийн засагт эерэг, бодитой хувь нэмэр оруулахын зэрэгцээ дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн зорилттой нийцсэн, урт хугацааны, харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн үр дүнг энэхүү БОНЗ-ын тайланд нэгтгэн танилцуулж байна.

Бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй салбаруудын ялгаатай байдлын улмаас бидний Тогтвортой хөгжлийн тайлан нь тайлагналын тодорхой нэгэн стандартыг шууд баримталдаггүй хэдий ч Тайлагналын олон улсын санаачилга (GRI), Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB) болон өөр бусад тайлагналын стандартын ерөнхий бүтэц, гол агуулга, хэмжигдэхүүнд суурилан гаргасан болно.





2024 оны онцлох үзүүлэлтүүд

Байгаль орчин

1,595 мянган
тонн CO₂-экв
хүлэмжийн хийг
түвшин 1 ба 2-ын хүрээнд
ялгаруулсан

9,900 тонн CO₂-экв
хүлэмжийн хийн
ялгарлыг бууруулсан

Эрчим хүчний хэмнэлт

1,365 МВт.ц

Сэргээгдэх эх үүсвэрээр үйлдвэрлэсэн цахилгаан

4,101 МВт.ц

758,267 тонн
усыг дахин ашигласан

672 тонн
үйл ажиллагааны хүрээнд
үүссэн хог хаягдлыг
дахин боловсруулсан

Нийгэм

14,000

Нийт ажилтан



30,968

ажилтан сургалтад
хамрагдсан
(давхардсан тоогоор)

эмэгтэй ажилтан



41%

эмэгтэй менежер



48%

гүйцэтгэх удирдлага



44%

4.4/5

Ажилтны сэтгэл
ханамжийн үнэлгээ



Нийгмийн хариуцлагын
төсөл, хөтөлбөр

Эдийн засагт оруулж буй хувь нэмэр

1.3 их наяд төгрөг
татвар, шимтгэлийг
төлсөн

4.6 их наяд төгрөг
Нийт худалдан авалт

3.1 их наяд төгрөг
Дотоод худалдан авалт

1.1 их наяд төгрөг
хөрөнгө оруулалтыг
Монгол Улсын эдийн
засагт оруулсан

90%

нийт худалдан авалтын
90 хувь нь “эх оронч”
худалдан авалт байжээ.

20,000+
шууд бус ажлын байр

55 тэрбум
төгрөгийг нийгмийн
хариуцлагын үйлсэд
зарцуулсан

Тогтвортой хөгжлийн стратеги

М-Си-Эс Групп байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоог үйл ажиллагаа эрхэлж буй бизнесийн салбар тус бүрийн онцлогт тохируулан хэрэгжүүлж байна.

Дэлгэрэнгүй



Байгаль орчин, нийгэм, засаглалын стратеги

М-Си-Эс Групп байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тогтолцоог үйл ажиллагаа эрхэлж буй бизнесийн салбар тус бүрийн онцлогт тохируулан хэрэгжүүлж байна. Үүний хүрээнд бид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөө бууруулж, нийгэмдээ ээлтэй, хариуцлагатай үйл ажиллагаа эрхлэхийг эрхэмлэн, урт хугацаандаа тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн, ил тод, хариуцлагатай засаглалыг бүрдүүлэхээр БОНЗ-ын стратегиа тодорхойлон үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

БОНЗ-ын стратеги



Байгаль орчин

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмрээ оруулах

Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, зохистой хэрэглээг дэмжих

Байгалийн нөөцийн зөв, зохистой хэрэглээ, биологийн олон янз байдлыг хамгаалах

Хог хаягдлын менежмент, хэрэглээг бууруулах



Нийгэм

Эрүүл, аюулгүй ажиллах орчныг бүрдүүлэх

Хөдөлмөрийн зохистой, үр ашигтай харилцааг эрхэмлэх

Жендерийн эрх тэгш, олон янз, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх

Нийгэмдээ хувь нэмрээ оруулах, оролцогч талуудтай харилцах



Засаглал

Ёс зүйтэй, хараат бус менежментийн арга барил бүхий зөв засаглалыг хөгжүүлэх

Хууль, дүрэм, журамд нийцсэн үйл ажиллагаа эрхлэх

Үнэн зөв, ил тод тайлагналын тогтолцоо бэхжүүлэх

Тогтвортой, хариуцлагатай нийлүүлэлтийн гинжин хэлхээг дэмжих

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга зам

М-Си-Эс Групп нь өөрсдийн үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг үе шаттайгаар бууруулах зорилгын хүрээнд олон улсын стандарт, арга зүйн дагуу тооцож эхэлсэн билээ. Ингэснээр урт хугацаандаа хүлэмжийн хийн ялгарлыг шат дараатай бууруулах бидний суурь алхам болсон юм.

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад дараах чиглэлүүдэд голчлон анхаарна:



Эрчим хүчний үр ашигтай хэрэглээ

- ✓ Дэвшилтэт техник, технологи ашиглах
- ✓ Бага нүүрстөрөгч бүхий хэрэглээнд шилжих



Сэргээгдэх эрчим хүч

- ✓ Цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг хэрэглээндээ нэвтрүүлэх
- ✓ Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдэд хөрөнгө оруулах



Малтмал түлшний хэрэглээг бууруулах

- ✓ Байгальд ээлтэй бусад эх үүсвэрт шилжих
- ✓ Түлшний хэмнэлтийг нэмэгдүүлэх



Үйл ажиллагаа, үйлдвэрлэлийг оновчлох

- ✓ Үйлдвэрлэлийн бүхий л явцад хүлэмжийн хийг хянах
- ✓ Шууд бус хүлэмжийн хийн ялгарлыг хянах
- ✓ Нийлүүлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх ялгарлыг хянах

Байгаль орчин

М-Си-Эс Группийн компаниуд түвшин 1 ба 2-ын хүрээнд хүлэмжийн хийн ялгарлаа тооцож, цаашид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгаруулахаас зайлсхийх арга хэмжээг авахаар зорин ажиллаж байна.

Дэлгэрэнгүй



1,595 мянган
тонн CO₂-экв

хүлэмжийн хийг түвшин
1 ба 2-ын хүрээнд
ялгаруулсан

9,900 тонн CO₂-экв

хүлэмжийн хийн
ялгарлыг бууруулсан

1,365 МВт.ц

эрчим хүчний
хэмнэлтийг бий
болгосон

4,101 МВт.ц

эрчим хүчийг сэргээгдэх
эх үүсвэрээр цахилгаан
үйлдвэрлэсэн

627 тонн

үйл ажиллагааны хүрээнд
үүссэн хог хаягдлыг
дахин боловсруулсан



Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах

Хүлэмжийн хийн ялгарал

М-Си-Эс Групп өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийг түвшин 1 ба 2 хүрээнд тооцоолон хэмжиж, хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах, ялгаруулахаас зайлсхийх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Цаашид бид хүлэмжийн хийн тооллого, тооцооллыг нарийвчлан, түвшин 3 хүрээнд тооцоолохоор бэлтгэж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний Хорооны (IPCC) болон "Хүлэмжийн хийн протокол"-ын арга зүйд тулгуурлаж, үйл ажиллагаа эрхэлж буй бизнесийн салбар бүрийнхээ онцлогт тохируулан 2024 онд арга зүйгээ шинэчлэн боловсруулсан.

Бид Киотогийн протоколд бүртгэлтэй хүлэмжийн хий болох нүүрсхүчлийн хий, метан, азотын хүчил, болон үйлдвэрлэлийн хийн ангилал болох ус фторт нүүрстөрөгчүүд, перфторт нүүрстөрөгчүүд зэргийг тооцоололдоо ашигласан.

Салбар	Түвшин 1	Түвшин 2
Эрчим хүчний салбар	4,283	2,356
Барилга, үл хөдлөх хөрөнгийн салбар	2,079	4,822
Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний салбар	4,871	11,575
Харилцаа холбооны салбар	600	72,626
Хөдөө аж ахуйн салбар	3,637	1,232
Эмнэлэг ба үйлчилгээний салбар	681	6,270
Уул уурхайн салбар	1,458,066	22,255
Хүлэмжийн хийн ялгарал салбараар, тонн CO ₂ -экв	1,474,218	121,137
Хүлэмжийн хийн ялгарлын түвшин		
Түвшин 1 (шууд ялгарал)	Үйл ажиллагааны явцад ялгарах хүлэмжийн хий	
Түвшин 2 (шууд бус ялгарал)	Худалдан авч буй цахилгаан ба дулаанаас үүсэх шууд бус ялгарах хүлэмжийн хий	



Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

М-Си-Эс Кока-Кола компани Монгол – Япон Улсын Засгийн газар хоорондын “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл”-ийн хүрээнд, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор нүүрсээр ажилладаг зуухыг халж, шингэрүүлсэн түлшээр ажилладаг агаарын бохирдол үүсгэдэггүй дэвшилтэт уурын зуухыг М-Си-Эс Интернэйшнл компанитай хамтран үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

4,800
тонн CO₂-экв

хүлэмжийн хийн
ялгарлыг бууруулсан

3,076 тонн CO₂-экв

Юнител Групп болон Эрчим Сүлжээ компаниуд нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашигласнаар

1,024 тонн CO₂-экв

М-Си-Эс Кока-Кола, Юнител Групп, Энержи Ресурс, М-Си-Эс Интернэйшнл, Интермед эмнэлэг, Шангри-Ла Улаанбаатар, Скай Резорт, Эрчим Сүлжээ компаниуд эрчим хүчийг хэмнэснээр агаар бохирдуулагч хий болон хүлэмжийн хий агаарт ялгарахаас сэргийлж байна.

4,100
тонн CO₂-экв

хүлэмжийн хийг агаар мандалд
ялгаруулахаас зайлсхийсэн




Эрчим хүчний менежмент

Эрчим хүчний хэмнэлт

М-Си-Эс Группийн зарим компани эрчим хүчний үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хувьд эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг гарган тайлагнаж, бууруулах арга хэмжээг авч ажилладаг. Тайлант хугацаанд хуучин төхөөрөмжүүдийг эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмжөөр шинэчлэх, цахилгаан эрчим хүчний хэрэглээг хянах, горим тохируулгыг оновчлох, гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй гэрлүүдээр солих, сайжруулах зэрэг арга замаар хэмнэлтийг бий болгоод байна.

Эрчим Сүлжээ компани цахилгаан эрчим хүч түгээх болон цахилгаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд энэ хүрээнд дэд станцын алдагдлыг бууруулах, эрчим хүч хэмнэж ажиллаж байна. Тайлант онд дэд станцуудын цахилгаан халаагууруудыг хэмнэлттэй технологиор сайжруулах, гэрэлтүүлгүүдийг шинэчлэх замаар хэмнэлтийг бий болгосон.



- хуучин гэрлийг эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлгээр сольж
- дулаан алдагдал бага, хэмнэлттэй технологийн шинэчлэл хийж
- эрчим хүчний хэрэглээг хянаж, горим тохируулгыг оновчилж
- бусад

898
МВт.ц

Энержи Ресурс

125
МВт.ц

Юнител Групп

72
МВт.ц

М-Си-Эс Кока-Кола

69
МВт.ц

Эрчим Сүлжээ

63
МВт.ц

Шангри-Ла Улаанбаатар

56
МВт.ц

М-Си-Эс Интернэйшнл

51
МВт.ц

Скай Резорт

31
МВт.ц

Интермед эмнэлэг

Эрчим хүчний хэмнэлтийн тухай сургалт, мэргэжлийн зөвлөгөө

Эрчим хүчний үүрэг хүлээсэн хэрэглэгч компаниуд цахилгаан эрчим хүч хэмнэх талаарх ажилтнуудын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, мэдээ мэдээллээр хангах сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг. Түүнчлэн ажилтнуудад цахилгаан эрчим хүчний зүй зохистой хэрэглээг төлөвшүүлэх, цахилгаан хэмнэх дадал суулгах зэрэг эрчим хүч хэмнэх аргуудыг хэрэгжүүллээ.

Эрчим Сүлжээ компани эрчим хүч хэмнэх төлөвлөгөө боловсруулан хэрэглэгчид, үүрэг хүлээсэн хэрэглэгчид, хэмнэлтийн менежерүүдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, тооцоолол, дүн шинжилгээ хийж үр ашгийг тооцох зэргээр төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилладаг. Тайлант онд 3,700 гаруй хэрэглэгчдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хэмнэлтийн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн ажилласан.



Эрчим хүчний менежмент

Цэвэр эрчим хүчний эх үүсвэр

4,101 МВт.ц

цахилгаан эрчим хүчийг Юнител Групп болон Эрчим сүлжээ компаниуд сэргээгдэх эх үүсвэрээр үйлдвэрлэж, ашигласан.

3,975 МВт.ц

Юнител Групп нийт 3,975 МВт.ц эрчим хүчийг сэргээгдэх эх үүсвэрээр үйлдвэрлэж, ашигласан ба нарны эрчим хүчээр ажилладаг 33 суурин станцыг шинээр суурилуулсан.

26,159 ГЖ

М-Си-Эс Интернэйшнл компани шингэрүүлсэн хийн түлшээр ажилладаг дэвшилтэт зуух ашиглан 26,159 ГЖ дулаан болон 38,681 тонн технологийн уурыг үйлдвэрлэжээ.

Эрчим хүчний менежмент

Эрчим хүчний үр ашигтай хэрэглээ

Эрчим хүчний үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хувьд М-Си-Эс Кока-Кола, М-Си-Эс Интернэйшнл, Скай Резорт, Энержи Ресурс компани болон Интермед эмнэлэг нь эрчим хүчний хэмнэлтийг бий болгохоос гадна үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэхээр нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулж буй эрчим хүчний хэрэглээгээ тогтмол хянадаг.

Компани	2023	2024
М-Си-Эс Кока-Кола нэг кВт.ц цахилгаан эрчим хүчээр үйлдвэрлэж буй литр бүтээгдэхүүний хэмжээ	19.9	19.7
М-Си-Эс Интернэйшнл нэгж цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд зарцуулж буй дотоод хэрэглээний хувь	9.7	9.5
Скай Резорт нэгж үйлчилгээнд зарцуулах эрчим хүч кВт.ц-аар	19	21
Интермед эмнэлэг нэгж үйлчилгээнд зарцуулах эрчим хүч кВт.ц-аар	28.6	68.1*
Энержи Ресурс нэг тонн нүүрс боловсруулахад зарцуулж буй эрчим хүч кВт.ц-аар	7.3	6.9

* Интермед эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажил болон, өргөтгөл ашиглалтад орсонтой холбоотой цахилгааны хэрэглээ нэмэгдсэн

Байгалийн нөөцийн зөв зохистой хэрэглээ

Усны дахин ашиглалт

М-Си-Эс Группийн хэмжээнд Энержи Ресурс, М-Си-Эс Кока-Кола, Мэтагро компаниуд үйлдвэрийн болон ахуйн хэрэглээнд зориулан ус цэвэршүүлэхээс гадна хэрэглэсэн хаягдал усыг өөрийн цэвэршүүлэх байгууламждаа цэвэршүүлэн боловсруулдаг.

М-Си-Эс Кока-Кола компанийн үйлдвэрийн хаягдал ус цэвэршүүлэх үйлдвэр тайлант онд 263 мянган тонн ус боловсруулсан. MNS 4943:2015 болон MNS 6734:2018 стандартын дагуу энэхүү цэвэршүүлсэн усыг хэрэглэгчдэд дахин ашиглах зориулалтаар үнэ төлбөргүй хүргэдэг.

Хэрэглэгчдээс дурдвал, гал унтраах анги, хот тохижилт үйлчилгээний байгууллагууд, авто угаалгын газрын хэрэглээ, мөн ногоон байгууламж, ойн усалгаа зэрэг багтаж байна. Тайлант онд 9,912 тонн буюу нийт цэвэршүүлсэн усны дөрвөн хувийг дахин ашиглажээ.



Энержи Ресурс компани Ухаа худаг уурхайн цогцолборт үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг ашигладаг. Усны хэрэглээ, хэмнэлт, дахин ашиглалт, хаягдал усны менежментийн хүрээнд MNS 4943:2015 стандарт, “Өмнийн говийн усны менежментийн Сайн дурын кодекс”-ийг мөрдөн ажилдаг.

Тайлант онд тус компани нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хаягдал усгүйжүүлэх үйлдвэрээс 748,355 тонн усыг дахин ашиглажээ. Мөн гадаргын ус цуглуулах цөөрөмд 115,000 тонн усыг цуглуулж, үйлдвэрийн болон бусад хэрэгцээнд дахин ашигласан.

Энержи Ресурс компани орон нутгийн 204,000 тонн ахуйн бохир усыг цэвэршүүлснээс 16,500 тонныг мод услах болон зам усалгаанд, 33,100 тонныг уурхайн тоос дарах зэрэгт тус тус ашигласан байна.

Усны үр ашигтай хэрэглээ

М-Си-Эс Группийн компаниуд ус ашиглах боломжит нөөцийн хүрээнд үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах зарчим баримтлан ажиллаж, үр ашигтай хэрэглээг хянадаг.

М-Си-Эс Кока-Кола компани 2024 онд нэг литр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 2.18 литр ус ашигласан байна.

Энержи Ресурс компанийн хувьд олборлолт, баяжуулалтын хэмжээнээс шалтгаалан усны ашиглалт, дахин ашиглалтын хэмжээ харилцан адилгүй байдаг ба баяжуулалтын нэг тонн тутамд ашигласан усны хэмжээ тайлант онд 170 литр байсан нь өмнөх онтой харьцуулахад 82 хувиар буурсан байна.

Мэтагро компани усалгаатай газар тариалан, болон мах үйлдвэрлэхэд ашиглах усны хэрэглээг тооцож, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажилладаг. 2024 онд нэг тонн мах боловсруулахад 11.4 тонн ус зарцуулсан байна.

🌱 Байгалийн нөөцийн зөв зохистой хэрэглээ Ойжуулалт

М-Си-Эс Группийн компаниуд уул уурхайн олборлолт, үйлдвэрийн эргэн тойронд биологийн нөхөн сэргээлт, газар тариалангийн бизнест ойн зурвас байгуулах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг бий болгох зорилгоор ойжуулалт, нөхөн тарилт, мод тарилтын арга хэмжээг хэрэгжүүлдэг.



Тайлант онд Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт Мэтагро компани газар тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурваст, өөрсдийн бойжуулсан хайлаас, бургас, улиас гэсэн 24,620 ширхэг модыг тарьж усалгаа, арчилгааг хийж байна.

Энержи Ресурс компани 2024 онд 15 төрөл зүйлийн модлог ургамлыг үр болон мөчрөөр үржүүлж, нийт 99,050 ширхэг мод тарьсан байна. Түүнчлэн Энержи Ресурс компани Хэнтий аймгийн Дадал сумын ойн сангийн доройтсон ойг нөхөн сэргээх зорилгоор 20 га талбайд 50 мянган мод, Цогтцэций сумын нутагт Ухаа худаг уурхайн хаягдлын овоолго болон уурхайн зам дагуу 19,050 ширхэг мод, Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутагт Заган ойжуулалт хийх зорилгоор 10 га талбайд 10 мянган заг мод тарьсан байна.

М-Си-Эс Группийн ажилтнууд Богдхан уулын Хүрхрээгийн ам орчмын доройтсон ой бүхий 13 га газарт 20 мянган шилмүүст мод, бусад байршилд 2,700 орчим мод тарьжээ.



Тарьц, суулгацын нөөц бүрдүүлэлт

Энержи Ресурс компани Цогтцэций суманд байрлах мод үржүүлгийн 2.5 га талбайдаа говийн нөхцөлд тохирсон олон төрлийн үр, суулгацыг бэлтгэдэг. 2024 онд энэхүү талбайдаа 15 төрөл, зүйлийн 49 мянган мод, сөөгийг мөчир болон үрээр тарин бойжуулж байна.

Мэтагро компани 1.7 га мод үржүүлгийн талбайд зургаан төрөл, зүйлийн 7 мянган мод, сөөгийг мөчир болон үрээр тарин бойжуулж байна.

Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

Энержи Ресурс компани Цогтцэций сумын нутагт орон сууц, олон нийтийн гудамж талбай болон ажилтны кэмпийн орчны тохижилтод зориулан 4,000 м² талбайд зүлэгжүүлэлт хийсэн.

М-Си-Эс Интернэйшнл компани Ухаа Худагийн цахилгаан станцын бүсэд 1,100 мод, Мэтагро компани Хэнтий аймагт байрлах ажилтны кэмпийн тохижилтод зориулан 1,200 орчим мод тарьжээ.





Биологийн олон янз байдал

Юнител Групп, Энержи Ресурс, Мэтагро, Эрчим Сүлжээ зэрэг компаниуд үйл ажиллагааны явцад тухайн бүс нутгийн экосистем, биологийн төрөл зүйл, тэдгээрийн амьдрах орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөх байдлыг үнэлдэг. Үүний хүрээнд тухайн бүс нутгийн байгаль орчны нөхцөлийг харгалзан үзсэн нь экологийн тэнцвэрт байдлыг хангах, байгалийн баялгийг хамгаалах зорилгоор зохих менежментийн арга хэмжээг цогцоор авч хэрэгжүүлэн, түүнийгээ тогтмол хянаж үнэлэх зорилгоор биологийн төрөл зүйлийн судалгаа, ажиглалтыг хийж байна.



Энержи Ресурс компани Ухаа худаг төслийн талбайд мэргэжлийн компаниар хээрийн мониторинг судалгаа хийж гүйцэтгүүлсэн. Судалгаагаар 20 орчим тоо толгой аргаль (үүнээс 6 угалз), 70 гаруй янгир, цагаан зээр 64 бүртгэгдсэн. Шувуудын хувьд 14 баг, 33 овогт багтах 126 зүйл шувуу бүртгэгдсэн ба тоо толгой нэмэгджээ.



Юнител Групп 2024 онд шинээр 48 хөв цөөрмийг байгуулж, цоохор ирвэс, мазаалай, аргаль, янгир, үнэг, тас, бүргэд зэрэг амьтдын ундны усны хэрэгцээг хангахад хувь нэмрээ оруулж байна. “Хөв, цөөрөм” төслийг эхлүүлснээс хойш 15 аймагт нийт 71 хөв, цөөрөм байгуулжээ.



Эрчим Сүлжээ компани шувуудын төрөл зүйлийг цахилгаан дамжуулах агаарын шугамын өндөр хүчдэлд цохиулах эрсдэлээс сэргийлэх зорилгоор тогтмол арга хэмжээ хэрэгжүүлж ажилладаг. 2024 онд нийт 3,862 метр урттай тусгаарлагч бүхий агаарын шугамыг 53 шон дээр суурилуулсан байна.



Мэтагро компани газар тариалангийн талбайн хашаанд нийт 15 шувууны үүрийг барьж байгуулсан. Үүний дүнд тухайн хээрийн бүс нутгийн экосистемийг тэтгэж, амьдрах орчныг бий болгох, шувууны тоо толгойг нэмэгдүүлэх зорилготой.



Хог хаягдлын менежмент

Бид үйл ажиллагаанаас үүсэх энгийн болон аюултай хог хаягдлыг зориулалтын дагуу боловсруулж, зохих арга хэмжээг авдаг.



627 тонн

Үйл ажиллагааны хүрээнд үүссэн оффисын болон бусад хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгсөн

2,241 тонн

Энгийн хог хаягдлыг хүлээлгэн өгч, зохих арга хэмжээг авсан

103 тонн

Аюултай хог хаягдлыг зориулалтын дагуу устгуулсан

2,682 тонн

Мэтагро компани 2,682 тонн хүнсний болон био-органик хаягдлыг дахин боловсруулж, ялзмаг болгон хувиргаж, газар тариалангийн хэрэглээнд дахин ашиглажээ.

387 тонн

М-Си-Эс Кока-Кола компани бүтээгдэхүүний сав, баглаа, боодлын жинг бууруулах алхмыг үргэлжлүүлэн хийсээр байгаа бөгөөд 2014 оноос хойш 387 тонн хуванцрын хэмнэлтийг уг арга хэмжээгээр бий болгожээ.



Хаягдал цуглуулах, дахин боловсруулах, ашиглах санаачилга

Хуванцар сав цуглуулах

М-Си-Эс Кока-Кола компани Улаанбаатар хот болон 16 аймагт хаягдал хүлээн авах цэгийг байгуулсан бөгөөд цугларсан хуванцрын хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгч байна.

Түүнчлэн нийт борлуулсан PET-1 тэмдэглэгээтэй бүтээгдэхүүний хуванцар савны 56 хувийг буцаан цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгсөн нь өмнөх онтой харьцуулахад 16 хувиар өсөөд байна.



Тотал Дистрибушин компани орон нутгийн таван аймгаас хуванцрын хаягдлыг буцаан цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгсөн ба тайлант онд орон нутгийн таван аймгаас 51.7 тонн хуванцрын хаягдлыг цуглуулан Улаанбаатар хот руу тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 44.7 хувиар өссөн байна.

Веллбий компани өөрсдийн борлуулж буй бүтээгдэхүүний хуванцар болон хөнгөн цагаан савыг хэрэглэгч, харилцагч байгууллагуудаасаа эргүүлэн авдаг.

Тайлант онд Вэллбий компани борлуулсан бүтээгдэхүүний HDPE-2, LDPE-4, PP-5 тэмдэглэгээтэй хуванцар болон хөнгөн цагаан хаягдлын 43 хувийг хамтран ажиллагч байгууллагуудаас, 2.3 хувийг хэрэглэгчдээсээ буцаан цуглуулсан байна.

No E-Waste

Юнител Групп Юнивишн үйлчилгээний хуучирч, амьдралын мөчлөгийн төгсгөлдөө хүрсэн төхөөрөмжүүдийг хэрэглэгчдээс буцаан цуглуулах зорилготой “No E-waste” кампанит нөлөөллийн ажлыг хоёр дахь жилдээ хэрэгжүүллээ. Тус кампанит ажлын хүрээнд олон нийтэд цахим хаягдлын тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх цуврал ажлуудыг зохион байгуулсан.

Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент

Юнител групп хаягдал төхөөрөмжүүдийг зохих журмын дагуу устгаж дахин боловсруулах зорилгоор 2024 онд 11,859 хуучин төхөөрөмжүүдийг хэрэглэгчдээсээ цуглуулж, дахин боловсруулалтад хүлээлгэн өгсөн байна. 2023 оноос хойш нийт 5.9 тонн буюу 25,650 төхөөрөмжийн цахим хаягдлыг цуглуулан устгууллаа.



Нийгэм

Бид олон талт байдал, ижил тэгш оролцоог компанийн засаглал, хүний нөөцийн бодлого, бизнесийн үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагын үйлсдээ шингээж, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг мөрдлөг болгон ажилладаг.

Дэлгэрэнгүй



14,000

Нийт ажилтан

30,968

Сургалтад хамрагдсан
ажилтны тоо

65,630

ажилтан ХАБЭА сургалт,
зааварчилгаанд хамрагдсан
(давхардсан тоогоор)

4.4

Ажилтны сэтгэл
ханамжийн үнэлгээ


98

Нийгмийн хариуцлагын
төсөл, хөтөлбөр
хэрэгжүүлсэн


Олон янз байдал ба хүртээмжтэй ажлын байр

Ажиллах орчин ба ажилтнууд:


Бид ажилтан бүртээ нээлттэй, хүртээмжтэй ажиллах орчныг бүрдүүлэн, хөдөлмөрийн оновчтой, үр ашигтай, итгэлцэл дээр суурилсан харилцааг бий болгон, ажилтан бүрийн үнэ цэнийг эрхэмлэж, шударга, эрх тэгш, хүйсийн тэнцвэртэй байдлыг хангасан, ажилтны сэтгэл ханамж, санал санаачилгыг дэмждэг байгууллагын соёлыг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна.



Хүйсийн тэнцвэрт байдал



Насны ангилалаар



Олон янз байдал ба хүртээмжтэй ажлын байр Хүртээмжтэй ажлын байр ба ажилтны оролцоо

Бид ажилтнууддаа хүртээмжтэй, уян хатан ажиллах орчныг санал болгохоос гадна ажилтны шинэ санал, санаачилгыг дэмжин, ижил тэгш боломжоор ханган ажилладаг.

Ажилтан бүрийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, байгууллагын үнэт зүйлсэд нийцсэн, харилцан итгэлцэл, эерэг уур амьсгал бүхий хамт олны соёлыг төлөвшүүлэхийг байгууллагын соёлын бодлогын тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлж байна.

АЖИЛТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖ

4.4

Бид ажилтны сэтгэл ханамжийн судалгааг нийт ажилтны дунд жил бүр зохион байгуулдаг ба сэтгэл ханамжийн үнэлгээг 14 үзүүлэлтээр тодорхойлж, жигнэсэн дунжийг гаргадаг.

АЖИЛТНЫ ОРОЛЦОО

4.5

Ажилтны оролцоо буюу компанийн үнэт зүйлийн төлөөх ажилтны хандлага, үйлдэл, итгэл үнэмшлийн түвшнийг найман үзүүлэлтээр тодорхойлон жигнэсэн дунжийг тооцдог.



Олон янз байдал ба хүртээмжтэй ажлын байр

Ажилтны хөнгөлөлт, хангамж

Бид ажилтнууддаа ажлаа сэтгэл ханамжтай гүйцэтгэх боломжийг бий болгох зорилгоор нийгмийн асуудал болон эрүүл мэндэд нь дэмжлэг үзүүлэн, хувь хүний хөгжилд нь тогтмол анхаарч, хамтдаа хөгжих орчныг бүрдүүлэхийг зорьдог.

2024 онд

14.5

тэрбум

төгрөгийн хөнгөлөлт,
хангамжийг ажилтнууддаа
олгосон.

Бэлэг



Хурим, хүүхдийн баяр,
шинэ төрсөн хүүхэд, ахмад
настны бэлэг

Хөнгөлөлт



Ажлын байрны зэрэг, онцлогоос
хамаарсан хоолны хөнгөлөлт,
боловсрол, эрүүл мэнд болон бусад
чиглэлийн бүтээгдэхүүн,
үйлчилгээний хөнгөлөлт

Чөлөө



Төрсөн өдрийн, шинэ хүүхэдтэй
болоход өгөх цалинтай чөлөө,
нийгэм, байгаль орчинд тустай сайн
дурын үйлсэд оролцоход өгөх
цалинтай чөлөө

Эрүүл мэнд



Эрүүл мэндийн
урьдчилан сэргийлэх үзлэг

Тэтгэмж, тусламж



Өндөр насны
нэг удаагийн тэтгэмж

Сургалт



М-Си-Эс Академи, гадаад,
дотоодын мэргэжлийн
сургалтуудад хамрагдах боломж

Даатгал



Үйл ажиллагааны онцлогоос
шалтгаалсан ажилтанд зориулсан
даатгал, хөнгөлөлттэй эрүүл
мэндийн даатгалд өөрийгөө болон
гэр бүлээ хамруулах боломж

Зээл



Хамтран ажиллагч
банкнуудаас хөнгөлөлттэй
нөхцөлөөр зээл авах боломжууд

**М-Си-Эс Группийн
хөнгөлөлт, хангамж**

Олон янз байдал ба хүртээмжтэй ажлын байр

Ажилтны хөнгөлөлт, хангамж

MCS Benefits платформ

Бид ажилтнууддаа хөнгөлөлт, хангамжийн багц журмын хүрээнд ашиглах боломжтой бүхий л мэдээллийг нэг дороос авч, Группийн компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “MCS Benefits” платформыг нэвтрүүлсэн билээ.

“MCS Benefits” платформуос хөнгөлөлттэй үнээр бараа, үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлж, дэмжих зорилгоор ажилтны үндсэн цалин дээр нэмэлт мөнгөн урамшууллыг тогтмол олгодог ба тайлант онд нийт 13.1 тэрбум төгрөгийг нэмэлт урамшуулал байдлаар ажилтнуудад олголоо.



13.1 тэрбум

төгрөгийн нэмэлт урамшууллыг
MCS Benefits платформуор
ажилтнууддаа олголоо

Ажилтны эрүүл мэнд

Ажилтнууд нь байгууллагын гол үнэ цэн болохын хувьд бид ажилтнуудынхаа сайн сайхан байдал, эрүүл мэнд, амьдралын чанарт онцгой анхаарал хандуулдаг билээ.

Үүний хүрээнд хөдөлмөрийн дотоод журмын дагуу бүх ажилтныг урьдчилсан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулж, ажилтанд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнддээ анхаарах боломжийг олгох замаар тогтвортой ажиллах орчныг бүрдүүлэх зорьдог ба тайлант онд урьдчилсан сэргийлэх эрт илрүүлэх үзлэгт нийт 1.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Хувийн эрүүл мэндийн даатгал

Эрүүл мэнд, учирч болзошгүй гэнэтийн эрсдэлд бэлэн байх, урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оноос эхлэн хувийн эрүүл мэндийн даатгалд гэр бүлийн хамтаар хөнгөлөлттэй үнээр хамрагдах боломжийг олгож эхэллээ.

Ажилтнуудын хэрэгцээ, шаардлагад тулгуурлан 30 сая төгрөг хүртэлх үнэлгээтэй буюу үйлчилгээний таатай нөхцөлтэй хувийн эрүүл мэндийн даатгалыг санал болгож байна.



Сайн дурын үйл ажиллагааг дэмжих Ажил олгогчийн дэмжлэгтэй сайн дурын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн хүрээнд нийгэм болон байгаль орчинд тустай мод тарих, хог цэвэрлэх, цус хандивлах, алслагдсан дүүргийн хүүхдүүдэд бэлэг цуглуулан тараах зэрэг сайн дурын үйлсэд М-Си-Эс Группийн 1,571 ажилтан, 5,297 цагийг зарцуулан оролцжээ.

Ажил олгогчийн дэмжлэгтэйгээр сайн дурын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр гэж юу вэ?



Ажилтан сайн дурын үндсэн дээр төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй нийгэм, байгаль орчинд тустай сайн дурын үйлсэд оролцож буй ажилтанд нэг өдрийн буюу найман цагийн цалинтай чөлөөг олгодог хөтөлбөр юм.

Сайн дурын ажлууд

Анунгоо компанийн ажилтнууд олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Налайх дүүргийн хүүхэд багачуудад гарын бэлэг гардууллаа.



Интермед эмнэлэг олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилтнуудын болон хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдүүдэд зориулан баярын үйл ажиллагаа зохион байгуулснаас гадна гэртээ баяраа тэмдэглэж чадахгүй байгаа хүүхдүүдэд зориулан гарын бэлгийг эмнэлгийн хамт олон бэлтгэн өгсөн байна.

Юнител Групп Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран “Be a Hero” өдөрлөгийг дотооддоо зохион байгуулан 45 ажилтан цусаа хандивласан ба 1,500 орчим хүнд шаардлагатай үед ашиглах цусны нөөцийг бүрдүүлсэн байна.

Юнител Группийн 18 насны ойн баяр 2024 онд тохиосонтой холбогдуулан ажилтнуудын санаачилсан “Жаргалтай гайхалтай” аяны хүрээнд 18 нас хүрч амьдралынхаа шинэ гарааг эхэлж буй 500 гаруй сурагчдад өөрсдийн гараар бэлдсэн шинэ жилийн бэлгийг урам зориг өгөх ил захидлын хамт илгээлээ.

Уг аяныхаа хүрээнд Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймагт суралцдаг хүүхдүүдэд мөн бэлэг гардуулсан. Түүнчлэн Юнител Группийн Борлуулалт, үйлчилгээний газрын хамт олон шинэ жилийн баяраар Нархан асрамж халамжийн төвийн 54 хүүхдэд бэлэг бэлдэж, баярын арга хэмжээ зохион байгуулсан.



Сургалт хөгжил ба чадавх бэхжүүлэх



Сургалтад хамрагдсан ажилтны тоо

30,968

М-Си-Эс
Академийн сургалт

500

Компани
доторх сургалт

267

Бусад сургалт

261

Нийт сургалтын тоо

1,028

Сургалтын нийт зардал

3.6 тэрбум төгрөг

MCS
ACADEMY



Сургалт хөгжил ба чадавх бэхжүүлэх М-Си-Эс Академи

Хамтдаа тасралтгүй хөгжих, мэдлэг, мэдээллээ бусадтайгаа хуваалцах зарчимд тулгуурлан ажилтнууд бие биеэ хөгжүүлэх боломжийг олгодог М-Си-Эс Академи нь 130 гаруй дотоодын сургагч багш, 100 гаруй сэдвээр ерөнхий болон мэргэжлийн ур чадвар, Группийн ажилтны суурь чадамжийг хөгжүүлэх сургалт, хөтөлбөрийг тогтмол зохион байгуулдаг.



10,500

ажилтан М-Си-Эс
Академийн сургалтад
хамрагдсан

Суурь чадамжийн үнэлгээ

М-Си-Эс Группийн сургалт, хөгжлийн бодлого нь ажилтныг тасралтгүй сургаж, хөгжүүлснээр байгууллагын өндөр чадавхийг бий болгох, бизнесийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах билээ. Ингэхдээ ажилтны хөгжүүлэх ур чадвар дээр тулгуурлан шаардлагатай сургалт, урт болон богино хугацааны хөтөлбөрөөр хангаж, ажилтны хөгжлийг хурдасгадаг.

Ажилтан өөрийн суурь чадамжийг үнэлэн хөгжүүлэх шаардлагатай ур чадвараа тодорхойлж, хувийн хөгжлийн төлөвлөгөө гарган жилийн туршид тасралтгүй сурч хөгждөг.

Сургалтын хөтөлбөрүүд:

21 сургалт	479 оролцогч	М-Си-Эс Менежментийн хөтөлбөр
7 сургалт	134 оролцогч	Менежерийн хөгжлийн хөтөлбөр
5 сургалт	127 оролцогч	Манлайллын хөтөлбөр
312 сургалт	6,255 оролцогч	Хувь хүний хөгжлийн хөтөлбөр
12 сургалт	270 оролцогч	Чиг үүргийн хөтөлбөр
82 сургалт	1,133 оролцогч	Ажилтны сайн сайхны хөтөлбөр



Сургалт хөгжил ба чадавх бэхжүүлэх М-Си-Эс Академи

Сургалтын нэгдсэн систем

Ажилтнууд М-Си-Эс Академийн онлайн хичээлүүдэд суух, сургалттай холбоотой мэдээ, мэдээлэл авах, өөрийн хөгжлийн төлөвлөгөөнд тулгуурлан хэрэгтэй сургалтыг сонгож, хамрагдах боломжийг сургалтын нэгдсэн систем (LMS) олгож байна.

Мөн ажилтан систем дээр өөрийн суурь чадамжийг үнэлэх боломжтой бөгөөд ур чадвараа хөгжүүлэх төлөвлөгөө гарган холбогдох сургалтуудад хамрагддаг.

М-Си-Эс Академийн сургалтын сайтад байршуулсан 40 гаруй онлайн сургалт, М-Си-Эс Группийн ажилтнуудын боловсруулсан 50 гаруй контент, нийтлэл, Группийн захирлууд болон сургагч багш нартай хийгдсэн подкастуудыг ажилтнууд нээлттэйгээр хүлээн авах боломжтой.



Хөдөлмөрийн аюулгүй байдал
ба эрүүл ахуй

М-Си-Эс Групп нь бүх ажилтан, туслан гүйцэтгэгчийн эрүүл, аюулгүй ажиллагааг ханган ажиллахыг зорьдог бөгөөд аюулгүй ажиллагааны дүрэм журмыг боловсруулах, мөрдөх, үйл ажиллагааг системчлэх, аюулгүй ажиллагааны соёлыг бэхжүүлэх, олон улсын туршлагыг нэвтрүүлэх зэрэг сайжруулалтыг тасралтгүй хийдэг билээ.

	2023	2024
ХАБЭА сургалт, зааварчилгаанд хамрагдсан ажилтны тоо	114,945	65,630
ХАБЭА сургалтад зарцуулсан нийт дүн (төгрөгөөр)	354 сая	314 сая
Хөдөлмөрийн чадвар түр алдсан ослын давтамж буюу LTIFR	0.17	0.18
100 ажилтанд ногдох ослын хүндрэлийн зэрэг буюу SR	5.12	3.54
Бууруулсан эрсдэлийн хэмжээ	79%	88%

Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж

Эрүүл мэндийн сургалт, зөвлөгөө

Анунгоо компани өсвөр насны охидод бэлгийн боловсрол олгох “Naturella dispenser” хөтөлбөрийг зохион байгууллаа. Хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн долоон дүүргийн 28 мянга гаруй сурагчдад охидын эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, сарын тэмдгийн үед хэрэглэх багц, ариун цэврийн хэрэглэлийн нэг сарын хэрэглээг бэлэглэсэн юм.



Эм, эрүүл мэндийн бүтээгдэхүүний хандив

Вэлбий компани эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор эм, амин дэм ба дархлаа сэргээх бэлдмэлийг эрүүл мэндийн байгууллагуудад үнэ төлбөргүй хандивладаг. Тус компани 2024 онд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, амаржих газрууд, дүүргийн болон орон нутгийн эмнэлгүүдэд 17 мянган эрүүл мэндийн бүтээгдэхүүн хандивлажээ.



Эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр

Энержи Ресурс компани орон нутагт эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэг, оношилгоог тогтмол зохион байгуулдаг.

Тайлант онд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч нарын “Хайрлая хуваалцъя” ТББ, Цогтцэций сумын сум дундын эмнэлэгтэй хамтран хүүхдийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг зохион байгуулж, Цогтцэций сумын 0-16 насны 900 хүүхдийг үнэ төлбөргүй үзлэгт хамрууллаа.



Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа Тэгш боловсрол

Оюутны тэтгэлэгт хөтөлбөр

М-Си-Эс Групп залуусын хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах, боловсролыг дэмжих зорилгоор “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг зарлан, найман их сургуулийн 78 оюутныг шалгаруулан тэтгэлэг гардууллаа.

Тэтгэлэгт хөтөлбөрт материалаа ирүүлсэн 850 оюутнуудын асуудал шийдвэрлэх чадвар, голч дүн, эсээ болон нэмэлт даалгавар биелүүлэх үзүүлэлт зэргийг нэгтгэн дүгнэснээр 37 мэргэжлийн 78 оюутныг шалгаруулсан юм.



 78 оюутанд нэг жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг өгсөн

 3 сарын хугацаанд цалинтай дадлага хийх боломж

 М-Си-Эс Академийн хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдах

 Салбар бүрийн шилдэг мэргэжилтнүүдээс суралцаж, ажлын бодит туршлага хуримтлуулах

 Их сургуулиа төгсөөд ажлын санал хүлээн авах боломжтой

Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа Тэгш боловсрол



"Unitel STEAM HUB" үндэсний хөтөлбөр

Юнител Групп боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, цахим хуваагдал, ур чадварын зөрүүг бууруулах, орон нутгийн иргэд, хүүхэд залуусын ШИМТ-ийн боловсролыг дэмжих, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой "Unitel STEAM HUB" үндэсний хөтөлбөрийг 2022 оноос санаачлан хэрэгжүүлж, 2024 оны байдлаар 20 аймагт үйл ажиллагаагаа өргөжүүлээд байна.

2024 онд робот угсрах, түүн дээрээ код бичих чадварыг олгодог "RoboKID" сургалтыг санал болгосноор нэг элсэлтэд 10-аас дээшгүй хүүхдийг хамруулж, нийт 20 аймагт 712 хүүхэд төгссөн.

Мөн тайлант онд сургалтын хөтөлбөрөө шинэчилж, дөрвөн шинэ сургалт нэмснээр хүүхдүүд гурав хүртэлх түвшин ахиж суралцах боломжтой болж, 6-14 насны хүүхдүүд хамрагдаж эхэлсэн юм.

Түүнчлэн, Стэнфордын болон Дюкийн их сургуулиудад бүрэн тэтгэлэгт хамрагдсан хоёр оюутан дэлхийн тэргүүлэгч их дээд сургуулиудад элсэх мэдлэгээ хуваалцах зорилгоор Баян-Өлгий, Увс, Ховд, Дорноговь, Дорнод, Архангай, Өвөрхангай аймгуудын Unitel STEAM HUB төвд "Бүх нийтийн боломж" сэдэвт сургалт семинарыг орсон.

Энэхүү өдөрлөгт долоон аймгийн 524 сурагч оролцсон ба гадаадын их, дээд сургуульд элсэх, тэтгэлэг авах, өргөдөл, материалаа бүрдүүлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн юм.

Миний мөрөөдөл

Тотал Дистрибьюшин компани жил бүр өөрийн ойн өдрөө тохиолдуулан сонсголын бэрхшээлтэй хүүхэд, залуусын унших, бичих, илтгэх ур чадварыг сайжруулж, өөрийгөө илэрхийлэх боломжийг олгох, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх зорилготой "Миний мөрөөдөл" эсээ бичлэгийн уралдааныг Монголын сонсголгүй иргэдийн "Диф" клубтэй хамтран зохион байгуулдаг уламжлалтай. Тав дахь жилдээ зохион байгуулсан энэ тэмцээнд 13 сургуулийн 80 хүүхэд, залуус оролцсон байна.



Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа Тэгш боловсрол

“Залуу манлайлал” хөтөлбөр

М банк залуусын хөгжил, манлайллыг дэмжих зорилгоор “Зориг сан” ТББ-аас зохион байгуулж буй “Young Leadership Program 2024” хөтөлбөрийг ивээн тэтгэж, хамтран ажиллаж байна. Энэхүү хөтөлбөр нь залуусын манлайлах чадвар, хувь хүний хөгжлийг дэмжих зорилготой бөгөөд олон талт сургалт, үйл ажиллагааг багтаадаг.



“Мөрөөдлийн хөтөч” сургалтын төв

Энержи Ресурс компани орон нутагт чанартай боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх, Цогтцэций сумын дунд сургуулийн ачааллыг бууруулах үүднээс “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэгийн цогцолборыг байгуулснаас гадна Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөрийг урт хугацаанд хэрэгжүүлж байна. Тайлант онд уурхайчдын “Цэций” хороололд байгуулсан “Мөрөөдлийн хөтөч” сургалтын төвийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийхийн сацуу сургалтын төвийн багш нарыг гэр бүлээрээ амьдрах орон сууцаар хангалаа.

Мөн Цогтцэций сумын нэгдүгээр дунд сургуулийн үйл ажиллагаанд хүндрэл үүссэнтэй холбоотойгоор 2024 оны 12 дугаар сараас тус сургуулийн 1-5 дугаар ангийн 425 хүүхдийг “Мөрөөдлийн хөтөч” сургалтын төвд хичээллэх боломжоор ханган ажиллаж байна.



“Цалинтай оюутан” хөтөлбөр

“Цалинтай оюутан” зуны хөтөлбөрт Өмнөговь аймгийн Цогтцэций, Цогт-Овоо, Ханхонгор сумын харьяат 20 оюутан хамрагдаж, хоёр сарын хугацаанд Ухаа худаг уурхайд түр хугацаанд туслах ажилтнаар цалинтай ажиллан ажлын бодит туршлага хуримтлууллаа.

“Кансат” үндэсний тэмцээн

ДДЭШТВ компани сансрын технологи, сансар судлалын шинжлэх ухаан, түүнд хамаарах инженер техникийн мэдлэг боловсролыг бодит төслөөр дамжуулан их, дээд сургуулийн оюутан залуус, сонирхогчийн бүлгэм, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад таниулан сурталчлах, дотоодын хүний нөөцийг бэлтгэх зорилго бүхий “Кансат” үндэсний тэмцээнийг ивээн тэтгэлээ.

Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

Цаг үеийн хандив, тусламж

М-Си-Эс Групп 2024 онд хаваржилт хүндэрсэн аймгуудад 1.1 тэрбум гаруй төгрөгийн тусламж, дэмжлэг үзүүлсэн. Тодруулбал, хаваржилтын эрсдэлийг даван туулахад туслах зорилгоор 500 сая төгрөгийн мөнгөн хандивыг Онцгой байдлын ерөнхий газарт хүлээлгэн өгсөн. Түүнчлэн М-Си-Эс Группийн хөрөнгө оруулалттай компаниуд 600 сая гаруй төгрөгийн үнэ бүхий бараа, бүтээгдэхүүн болон үйлчилгээгээр орон нутагт дэмжлэг үзүүлсэн юм.

Тухайлбал, Юнител Группээс 150 сая төгрөгийн үнэ бүхий хөдөлгөөнт интернэт, мессежийн үйлчилгээг Онцгой байдлын ерөнхий газрын 21 аймгийн 2,800 гаруй ажилтанд гурван сарын хугацаанд үнэ төлбөргүй олгохоор болсон бол М-Си-Эс Кока-Кола, Тотал Дистрибьюшин, Вэллбий, ДДэшТВ компаниуд нийт 50 сая төгрөгийн үнэ бүхий бараа, үйлчилгээгээр дэмжлэг үзүүлсэн.

Түүнчлэн Энержи Ресурс компани жил бүр орон нутгийн малчдад үзүүлдэг тусламжаа өргөжүүлэн Өмнөговь аймгийн зүүн бүсийн сумдад 300 орчим сая төгрөгийн үнэ бүхий өвс, тэжээл, эд материал, хүн хүч болон техникийн тусалцааг үзүүлсэн. Мөн Энержи Ресурс компанийн хөрөнгө оруулалттай Эрдэнэ Монгол компани Баянхонгор аймгийн Шинэжинст, Баянговь сумдын малчдад тусламж болгон 120 орчим сая төгрөгийн өвс, тэжээлийг бэлтгэн, түгээжээ.

Мэтагро компани Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт үүссэн хүчтэй шуурганы улмаас цасанд боогдсон зам, гарц болон малын бэлчээрийг хүчит техник, төхөөрөмж ашиглан нээж, цэвэрлэх ажлыг зохион байгуулсан байна.



1.1 тэрбум

төгрөгийн тусламж, дэмжлэгийг хаваржилт хүндэрсэн аймгуудад өгсөн



Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

Орон нутгийн иргэдэд чиглэсэн арга хэмжээ

Энержи Ресурс компани нийгэм, орон нутагт чиглэсэн, урт хугацааны үр өгөөжтэй төсөл, хөтөлбөрүүдийг оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлж ирсэн ба 2024 онд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн төсөл, хөтөлбөрт нийт 70 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, хандив тусламжийг олгосон байна.



70 тэрбум

төгрөгийг Энержи Ресурс компани хөрөнгө оруулалт, хандив тусламж хэлбэрээр олгожээ.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих

Орон нутгийн малчид, иргэдийн жижиг, дунд бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор Хас банктай хамтран хэрэгжүүлдэг “Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 19 иргэнд 193 сая төгрөгийн хүүгүй зээл олгосон.

Газар тариалан эрхлэлтийг дэмжих

Энержи Ресурс компани ойн зурвасын найман га талбайг Цогтцэций сумын иргэдийн газар тариалан эрхлэх идэвх, санаачилгыг нь дэмжих, туршлага, ур чадварыг нь нэмэгдүүлэх, цаашлаад өрхийн бизнесийг нь чадавхжуулах зорилгоор ашиглуулдаг. 2024 онд ойн зурвасын 4 га талбайд Цогтцэций сумын 43 өрх, нэг хоршоо 20 гаруй төрлийн хүнсний ногоо тариалж, 8 тонн ургац хураан авлаа. Мөн дуслын усалгааны системтэй болгож сайжруулалт хийсэн байна.



“Сайн хөрш” хөтөлбөр

Энержи Ресурс компани Цогтцэций сумын иргэдийг цахилгаан болон цэвэршүүлсэн усаар тогтмол хангахаас гадна Даланзадгад сумын цахилгаан станц, Өмнөговь аймгийн 11 сумдад 46 мянга орчим тонн дулааны нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлжээ.

Мөн нөлөөллийн бүсийн 430 малчинд болон Цогтцэций, Цогт-Овоо сумын фондод нийт 11,000 боодол өвс, 1,800 боодол тэжээл хандивласан юм.

Малчдыг дэмжих аян

Мэтагро компани Хэнтий аймгийн Өлзийт тосгонд оршин суух малчид, иргэдийг дэмжиж, өвөлжилтөд бэлтгэхэд нь туслах зорилгоор тариан талбайнхаа захалгаанаас хадланд зориулан боодол олгохоос гадна, Цагаан сарын баярыг тохиолдуулан тосгоны ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн юм.

Түүнчлэн цас ихээр орсны улмаас зам хаагдаж, бэлчээрт цасан бүрхүүл тогтсоныг арилгаж, нийт 340 км зам цэвэрлэж, нэвтрэх боломжтой болгосноос гадна, малчин, айл өрхүүдэд зориулан 355 га бэлчээрийн талбай гаргаж өгсөн байна.



Засаглал

М-Си-Эс Групп нь засаглалын цогц тогтолцооныхоо хүрээнд үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн зорилго, ойлголтуудыг тусган хэрэгжүүлж, оролцогч талууддаа урт хугацааны үр ашгийг бий болгохыг зорин ажилладаг.

Дэлгэрэнгүй



Засаглалын бүтэц

М-Си-Эс Групп нь засаглалын цогц тогтолцооныхоо хүрээнд үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн зорилго, ойлголтуудыг тусган хэрэгжүүлж, оролцогч талууддаа урт хугацааны үр ашгийг бий болгохоор ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл				
Аудит ба эрсдэлийн хороо	Ёс зүйн хороо	Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо	Томилгоо, урамшууллын хороо	Санхүү, хөрөнгө оруулалтын хороо
Хараат бус, мэргэжлийн хяналт, зөвлөгөө өгөх чиг үүрэгтэй. М-Си-Эс Группийн дотоод аудит, хяналтын тогтолцоо, эрсдэлийн менежмент, нийцлийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр нөлөөг хянах, хөндлөнгийн аудитын байгууллагуудтай харилцаж, тэдгээрийн дүгнэлтэд тулгуурлан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явцыг удирддаг.	М-Си-Эс Группийн хэмжээнд ёс зүйн өндөр стандартыг төлөвшүүлж, хэвшүүлэх зорилгоор хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулдаг. Холбогдох дүрэм, бодлого, журам болон хууль, эрх зүйн шаардлагад нийцүүлэн бүх харьяа компани болон оролцогч талууд ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөхөд нь дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьдаг.	Тогтвортой хөгжлийн бодлого, стратегийг боловсруулж хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд БОНЗ-ын үзүүлэлтэд суурилсан шийдвэрүүдийг гаргадаг. М-Си-Эс Группийн бизнесийн үйл ажиллагаа, гүйцэтгэлд нөлөөлж болохуйц асуудлын эрсдэл, боломжийг үнэлэх, зохих хяналтыг тавих, оролцогч талуудад мэдээлэх явцыг удирддаг.	Бизнесийн стратеги, зорилтдоо хүрэх, бизнесээ тогтвортой хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, компанийн засаглалыг ил тод, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн залгамж халааны төлөвлөгөө болон цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад менежментийн багийн гишүүдийг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх асуудалд хяналт тавьж ажилладаг.	Группийн хөрөнгө оруулалтын стратеги, бодлогыг тодорхойлж, бизнесийн урт болон богино хугацааны санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хяналт тавьж, хөрөнгө оруулалтын нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэх замаар хөрөнгө, төсвийг үр дүнтэй удирдах, бизнесийн ашигт ажиллагааг хангуулах чиг үүрэгтэй ажилладаг.



Засаглалын бүтэц

Дотоод аудит

М-Си-Эс Группийн Дотоод аудитын алба нь хараат бус, бие даасан нэгж бөгөөд байгууллагын эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, засаглалын тогтолцооны үр дүнтэй байдлыг дотоод аудитын мэргэжлийн үүднээс системтэйгээр үнэлж, үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, сайжруулах замаар байгууллагыг зорилгодоо хүрэхэд дэмжлэг үзүүлдэг.

Дотоод аудитын алба нь баталгаажуулах болон зөвлөгөө өгөх чиг үүргийг хараат бус байдал, нууцлал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг чандлан мөрдөж М-Си-Эс Группийн хэмжээнд хэрэгжүүлдэг бөгөөд тайлант онд М-Си-Эс Группийн Дотоод аудитын дүрмийг шинэчлэн баталсан.

Эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөөг улирал, жилээр нь төлөвлөн боловсруулж, Аудит ба эрсдэлийн хороогоор батлуулан хэрэгжүүлж, үр дүнгийн тайлан, дүгнэлт, зөвлөмжийг тухайн компанийн удирдлага, Аудит ба эрсдэлийн хороо, төлөөлөн удирдах зөвлөл болон шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдэд танилцуулдаг.



📁

Эрсдэлийн менежмент

М-Си-Эс Групп ISO 31000:2018 стандартын дагуу эрсдэлийн менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, бизнесийн зорилго, стратеги болон үйл ажиллагаанд учирч болзошгүй, тодорхой бус нөлөөллийг системтэйгээр илрүүлэн, удирдаж, тасралтгүй сайжруулан ажилладаг.

Хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурласан Эрсдэлийн менежментийн тогтолцоог хэрэгжүүлснээр эрсдэлийг удирдах үүрэг, хариуцлага, хяналтын шат бүрийг тодорхой болгож, бүх түвшний оролцоог хангах ач холбогдолтой.





Эрсдэлийн менежмент

Эрсдэлийн соёл

М-Си-Эс Группийн эрсдэлийн менежментийн тогтолцооны салшгүй нэгэн хэсэг нь эрсдэлийн соёл юм. Бид өдөр тутмын үйл ажиллагаандаа эрсдэлийн соёлыг дадал, үнэт зүйл, хандлага болгохоор зорьж ажилладаг. Тайлант хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд байгууллагын бүх түвшинд эрсдэлийн талаарх мэдлэг, хандлага сайжирч, эрсдэлийг зөвөөр таньж, удирдах тогтолцоо улам боловсронгуй болж байгаа нь М-Си-Эс Группийн тогтвортой хөгжил болон бизнесийн үнэт зүйлийг хамгаалах бат бөх үндэс суурь болж буй юм.

УДИРДЛАГЫН БАГИЙН ОРОЛЦОО:



Харьяа компаниудын удирдлагын багуудад зориулсан тусгай сургалтууд зохион байгуулж, эрсдэлийн талаар зөв ойлголт хүргэж, шийдвэр гаргахдаа тусган хэрэгжүүлэх оролцоог нэмэгдүүлж байна.

ЭРСДЭЛИЙН ТӨЛӨВШЛИЙН ҮНЭЛГЭЭ:



Компанийн түвшинд эрсдэлийн соёлын төлөвшлийн үнэлгээг хийж, тасралтгүй сайжруулах арга хэмжээг тодорхойлж, удирдлагын багт зөвлөмж, чиглэл өгсөн.

СУРГАЛТ БА ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭЛТ:



Эрсдэлийн менежментийн талаар сургалт, мэдээллийн арга хэмжээг өргөжүүлж, эрсдэлийг таньж, мэдээлэх, удирдах дадлыг төлөвшүүлснээр ажилтнуудын оролцоог нэмэгдүүлж байна.

УДИРДЛАГЫН ТҮВШНИЙ МАНЛАЙЛАЛ:



Эрсдэлийн талаар удирдлагын түвшинд тогтмол хэлэлцэж, байгууллагын шийдвэр гаргалтад тусгаж ирснээр манлайллыг бэхжүүлж, бүх түвшний ажилтнуудад үлгэр жишээ болж байна.



Нийцлийн удирдлагын тогтолцоо

М-Си-Эс Группийн нийцлийн удирдлагын тогтолцоо нь бизнесийн үйл ажиллагааг хууль, тогтоомжид нийцүүлэх, комплаенсийн хяналтыг хэрэгжүүлэх замаар эрсдэлийг удирдах, нийцлийн соёлыг төлөвшүүлэхэд чиглэдэг. Энэ тогтолцоо нь удирдлага, зохион байгуулалтын бүтэц, нийцлийн бодлого, дүрэм, журам болон нийцлийн цогц үйл ажиллагаанаас бүрддэг.

Бодлого, журам

2021 онд **ISO 37301:2021** Комплаенсийн удирдлагын тогтолцоо, стандартад үндэслэн харилцан уялдаа бүхий нийцлийн багц журмыг шинэчлэн баталсан. Үүнд:

Нийцлийн бодлого

М-Си-Эс Группийн охин болон хөрөнгө оруулалттай компаниудад нийцлийн удирдлагын тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн нэвтрүүлсэн. Энэхүү бодлогоор нийцлийн үйл ажиллагааны зорилго, зорилт, цар хүрээ, баримтлах зарчим, төлөвлөлт, тайлагнал зэрэг харилцааг зохицуулсан.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам

Хамтран ажиллаж буй харилцагчийг таньж мэдэх, магадлан шалгах ажиллагааг тогтмолжуулж, эрсдэлт нөхцөл байдлыг мэдээлэх, мэдэгдэх, хяналт тавих зохицуулалтуудыг шинэчлэн тодорхойлсон.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам

Ажилтан бүр авлига, хээл хахуулын аливаа хэлбэрээс ангид байх зарчмыг бэхжүүлж, үйл ажиллагаандаа энэ төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж, авлигыг мэдээлэх, мэдэгдэх, хариуцлагыг дээшлүүлэх механизмыг тодорхойлсон.

Улс төрийн хандивын журам

Улс төрийн хандивыг хуульд заасан шаардлагуудыг бүрэн хангасан, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх, хандив олгоход толгой компанийн зүгээс хяналт тавих харилцааг Группийн хэмжээнд зохицуулсан.



Нийцлийн удирдлагын тогтолцоо

Хяналт, удирдлага

Нийцлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн хяналтын чиг үүргийг М-Си-Эс Группийн нийцлийн нэгж, ажилтан хариуцаж ажилладаг.

Энэ хүрээнд нийцлийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, нийцлийн соёлыг бүрдүүлэх чиглэлээр сургалт, мэдээллээр ажилтнуудыг хангах замаар нийцлийн удирдлагыг компанийн хэмжээнд хэрэгжүүлж байна.

Нийцлийн сургалт

Бид бизнесийн үйл ажиллагаа бүрд үүсэж болзошгүй нийцлийн эрсдэлийг үнэлж, тухайн эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн нийцлийн сургалтыг жил тутам зохион байгуулдаг.

Ёс зүйн дүрэм, ашиг сонирхлын зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх олон улсын баримт бичиг, бизнес ба хориг арга хэмжээ гэх мэт комплаенсийн талаар онцлох сэдвүүдийг хамарсан сургалтыг нийцлийн болон холбогдох чиг үүргийн болон шинээр ажилд орсон ажилтнуудад тогтмол зохион байгуулж байна.





Спийк-аут

Ёс зүйн хороо нь ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах албан ёсны суваг болох SpeakOut зөрчил мэдээлэх системийг ажиллуулдаг.

Энэхүү системээр мэдээлэгч нь М-Си-Эс Группийн охин болон хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагаатай холбоотой ашиг сонирхлын ба хүний эрхийн зөрчил, авлига, хээл хахууль, ёс зүйн болон хууль, дүрэм, журмын зөрчлийн талаарх мэдээллийг нууцлалтай, шударгаар хүргэж, шаардлагатай тохиолдолд ёс зүйн хорооноос зөвлөмж, чиглэл өгч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлдэг.

SpeakOut нь мэдээлэгчийг хамгаалах, зөрчлийг цаг алдалгүй илрүүлэх, эрсдэлийг бууруулах, компанийн үнэт зүйлсийг баталгаажуулах үндсэн арга хэрэгслийн нэг юм.

Ёс зүйн хороо нь зөрчлийн талаар мэдээллийн шинж чанараас хамааран хамгийн багадаа ажлын 10 өдрийн дотор хянан хэлэлцэж, зохих шийдвэрийг гаргадаг



Зөрчлийг хэрхэн мэдээлэх вэ?



☎ 8888-2027

🌐 speakout@mcs.mn

🌐 speakout.mcs.mn




Тогтвортой нийлүүлэлтийн гинжин хэлхээ ба худалдан авалт

М-Си-Эс Групп нь аливаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжин бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нь худалдан авахыг эрмэлздэг. Үүний хүрээнд бид нийлүүлэгчдэдээ өрсөлдөөний тэгш боломжийг хангах зорилгоор худалдан авалтын урилгыг албан ёсны сувгаар нээлттэй зарлаж, хамтран ажиллах хүсэлтэй шинэ нийлүүлэгчдийг байнга татан оролцуулдаг.

М-Си-Эс Группийн охин болон хөрөнгө оруулалттай компаниуд 2024 онд нийт 4.6 их наяд төгрөгийн худалдан авалт хийснээс 3.1 их наяд төгрөгийн бараа, ажил үйлчилгээг дотоодын 8,600 гаруй бизнес эрхлэгчдээс авсан ба нийт хамтран ажилласан нийлүүлэгчийн 90 хувь нь дотоодын аж ахуйн нэгж, хувь хүн байгаа юм.

Түүнчлэн М-Си-Эс Группийн үнэт зүйлсийг нийлүүлэлтийн гинжин хэлхээгээр дамжуулан түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн нийлүүлэгч бүрийн дагаж мөрдөх “[Нийлүүлэгчийн ёс зүйн дүрэм](#)”-ийг хамтран ажилладаг нийлүүлэгчдэдээ, тэдгээрийн ажиллагсад, төлөөлөгч, холбоо хамаарал бүхий хуулийн этгээд болон туслан гүйцэтгэгчдэд тайлбарлан таниулж, мөрдүүлэн ажилладаг.

Бид худалдан авах ажиллагааг нээлттэй, шударга, зах зээлийн өрсөлдөөнт үнэд суурилсан, үр ашигтай, хариуцлагатай байх зарчим баримтлан гүйцэтгэдэг ба тэгш өрсөлдөөнийг хангахын тулд 10 сая төгрөгөөс дээш худалдан авалтыг гурваас доошгүй нийлүүлэгчээс санал авч, харьцуулсны үндсэн дээр шалгаруулдаг.



3.1 их наяд

төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг дотоодын бизнес эрхлэгчдээс авсан.

8,619

дотоодын компани болон хувь хүнтэй хамтран ажилласан.

90%

2024 онд хамтарч ажилласан нийлүүлэгчийн 90 хувь нь үндэсний компани байсан.



Тогтвортой нийлүүлэлтийн гинжин хэлхээ ба худалдан авалт

Нийлүүлэгчийн портал

М-Си-Эс Группийн хэмжээнд зарлаж буй худалдан авалтын зарыг ил тод, хүртээмжтэй хүргэж, шинээр зарласан худалдан авалтын мэдээллийг нэг дороос харах, худалдан авалтад бүртгүүлэх, үнийн санал илгээх, шалгаруулалтын үйл явцыг хянах боломжийг бүрдүүлсэн Нийлүүлэгчийн порталаар дамжуулан хүргэдэг.

2024 оны байдлаар

М-Си-Эс Группийн Нийлүүлэгчийн порталд:


М-Си-Эс Группийн

35 компани

Нээлттэй зарласан худалдан авалтын зарын тоо

1,000+

Нийлүүлэгчээр бүртгүүлэх



 Эдийн засагт оруулж буй хувь нэмэр
М-Си-Эс Группийн охин болон хөрөнгө оруулалттай
компаниуд 2024 онд

1.3 их наяд

төгрөгийн татвар, шимтгэлийг
улсын төсөвт оруулсан.

1.1 их наяд

төгрөгийн хөрөнгө оруулалтыг
Монгол Улсын эдийн засагт
хийсэн.

55 тэрбум


төгрөгийг нийгмийн
хариуцлагын 98 төсөл, хөтөлбөрт
зарцуулсан.

60 тэрбум

14 мянган ажилтандаа сард
60 орчим тэрбум төгрөгийн цалин,
урамшууллыг олгосон.

20,000+

шууд бус ажлын байрыг бий
болгосон.



Худалдан авалт



4.6 их наяд

төгрөгийн худалдан авалт
хийснээс

3.1 их наяд

төгрөгийн бараа, ажил
үйлчилгээг

8,619

дотоодын аж ахуйн нэгж,
бизнес эрхлэгчдээс авсан.

90%

нийт худалдан авалтынхаа
90 хувь нь “эх оронч” худалдан
авалт байжээ.



Товчилсон үгийн жагсаалт

PET	Полиэтилен терефталат
БОНЗ	Байгаль орчин, нийгэм, засаглал
GRI	Тайлагналын олон улсын санаачилга
SASB	Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
IPCC	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний Хороо
HDPE	Өндөр нягтралтай полиэтилен
LDPE	Бага нягтралтай полиэтилен
PP	Полипропилен
ТББ	Төрийн бус байгууллага
ШИМТ	Шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

Нэгжийн тайлбар

CO ₂	Нүүрстөрөгчийн давхар исэл
МВт.ц	Мегаватт цаг
ГЖ	Гигажоуль
кВт.ц	Киловатт цаг
га	Арван мянган хавтгай дөрвөлжин метр
м ²	Хавтгай дөрвөлжин метр
кг	Килограмм



Дэлхийн хөгжлийг Монголд